

Газар зүйн мэдээллийн системд суурилсан төлөвлөлт, хөгжүүлэлт, зохицуулалт хариуцсан шинжээч, Төмөрбаатар Амартүвшин

2024 ОНЫ ХАГАС ЖИЛ-Н ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

НЭГ. ГҮЙЦЭТГЭЛИЙН ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭНИЙ БИЕЛЭЛТ

№	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин				
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин / биелэлт	Эхэлсэн, дууссан хугаца	Биелэлтийн хувь
			1	2	3	4	5
1.1. 1.2.Боловсрол, шинжлэх ухааны хууль тогтоомжид заасан эрх зүйн актыг боловсруулж, батлуулах, хэрэгжилтэд мэргэжил арга зүйгээр хангах, олон нийтэд сурталчлан таниулах ажлыг зохион байгуулсан байх							
1	Боловсрол, шинжлэх ухааны хууль тогтоомжид заасан эрх зүйн актыг боловсруулж, батлуулах, хэрэгжилтэд мэргэжил арга зүйгээр хангах, олон нийтэд сурталчлан таниулах ажлыг зохион байгуулсан байх	-	Арга хэмжээний хэрэгжилтээр	Арга хэмжээний хэрэгжилтээр	Боловсрол, шинжлэх ухааны яамны Төрийн нарийн бичгийн даргын 2024 оны 03 дугаар сарын 22-ны өдрийн “Ажлын хэсгийн бүхэлдэхүүн, удирдамж, зардал батлах тухай” А/61 дүгээр тушаал баталсан. Энэхүү тушаалаар яам, Монголын боловсрол, шинжлэх ухааны үйлдвэрчний эвлэлийн холбоо хооронд 2024-2026 онд байгуулсан хамтын хэлэлцээрийн 2.2-д заасан Боловсролын хууль тогтоомж холбогдох дүрэм, журмын олон нийтэд сурталчлан таниулах ажлыг зохион	1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар	Өөрийн үнэлгээ: 100% Нэгжийн даргын үнэлгээ: 100% Нэгжийн даргын үнэлгээ төлөвлөсөн хугацаандаа гүйцэтгэсэн байдал: 100%

					байгуулах үүрэг бүхий ажлын хэсгийн бүрэлдэхүүнд 3 дугаар багийн гишүүнээр томилогдон ажилласан. Тус баг нь 2024 оны 03 дугаар сарын 25-ны өдөр Чингэлтэй, Сүхбаатар дүүрэгт, мөн сарын 28-ны өдөр Багануур дүүрэгт, 3 дугаар сарын 31-ний өдрөөс 4 дүгээр сарын 07-ний өдрийг хүртэл Говь-Алтай, Баянхонгор, Өвөрхангай аймагт, 5 дугаар сарын 05-ны өдрөөс 12-ны өдрийг дуустал Хөвсгөл, Булган, Орхон аймагт боловсролын багц хуулийг сурталчлан таниулах ажлыг нийт 730 гаруй цэцэрлэгийн эрхлэгч, сургуулийн захирал, Үйлдвэрчний эвлэлийн хороодын дарга, сургалтын менежер, нийгмийн ажилтан, нягтлан бодогч нарт зохион байгуулан ажиллалаа. Хавсралт: 4 файл		
2	Монгол Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөөний төсөлд боловсрол, шинжлэх ухааны асуудлаар	Монгол Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөөнд тусгах санал	Монгол Улсын хөгжлийн 2024 оны төлөвлөгөөнд 12 асуудал	Төлөвлөгөөний төсөлд тусгуулах саналыг Эдийн засаг, хөгжлийн яаманд	Эдийн засаг, хөгжлийн яамнаас 2024 оны 01 дүгээр сарын 03-ны өдөр зохион байгуулсан “Монгол Улсын хөгжлийн	1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар	Өөрийн үнэлгээ: 100% Нэгжийн даргын үнэлгээ:

	тусгуулах санал боловсруулна.		тусгагдсан.	хүргүүлсэн байна.	төлөвлөгөө боловсруулах аргачлал” сургалтад ахлах шинжээч Б.Бадамжавын хамт хамрагдаж, Монгол Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөөний төсөлд тусгуулах 28 саналыг холбогдох газар, нэгжүүдтэй санал, судалгаа, мэдээлэл авч, тус төлөвлөгөө боловсруулах аргачлалын дагуу боловсруулж ажилласан. Саналыг сайдын 2024 оны 01 дүгээр сарын 15-ны өдрийн 1а/168 тоот албан бичгээр Эдийн засаг, хөгжлийн сайдад хүргүүлсэн. Хавсралт: 2 файл		80% Нэгжийн даргын үнэлгээ төлөвлөсөн хугацаандаа гүйцэтгэсэн байдал: 100%
3	Сургалтын байгууллагын бүтэц, зохион байгуулалтыг бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалтай нийцүүлэн дахин төлөвлөлт хийх зураглал, хөрөнгө оруулалтын төлөвлөгөө боловсруулах	Бүтэц, зохион байгуулалтын талаар баримтлах чиглэл	-	Удирдамж	Хугацаа болоогүй. Дэлхий дахинд баримталж буй ирээдүй хойч үедээ унаган байгалийг алдагдуулахгүй өвлүүлэх тогтвортой хөгжлийн үзэл санаа, орчин үеийн онолын чиг хандлага, хот, хөдөөгийн хөгжлийг тэнцвэржүүлэх практик хэрэгцээ шаардлагаас үүдэн "Монгол Улсын бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал"-ыг шинэчлэн боловсруулах ажлын хүрээнд Эдийн засаг,	1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар	Өөрийн үнэлгээ: 40% Нэгжийн даргын үнэлгээ: 20% Нэгжийн даргын үнэлгээ төлөвлөсөн хугацаандаа гүйцэтгэсэн байдал: 50%

					хөгжлийн яамны холбогдох ажлын хэсэгтэй нэгжийн дарга, ахлах шинжээчийн хамт 2 удаагийн уулзалтад оролцож, санал солилцсон. Шинэчлэн боловсруулсан “Монгол Улсын бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал”-ыг Эдийн засаг, хөгжлийн сайд 2024 оны 05 дугаар сарын 28-ны өдөр Монгол Улсын Их Хурлын даргад өргөн барилаа. Тус үзэл баримтлалд 6 бүлэг, 1 эрхэм зорилго, 7 зорилго, 197 зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн бөгөөд Монгол Улсыг эдийн засгийн “Хангайн, Баруун, Хойд, Төвийн, Зүүн, Говийн, Улаанбаатарын” гэсэн долоон бүсчлэлийн тогтолцоогоор хөгжүүлэхээр тодорхойллоо.. Үүнд: • Хангайн бүсэд: Архангай, Баянхонгор, Өвөрхангай аймаг; • Баруун бүсэд: Баян-Өлгий, Говь-Алтай, Завхан, Увс, Ховд аймаг; • Хойд бүсэд: Булган, Орхон, Хөвсгөл аймаг; • Төвийн бүсэд: Дархан-Уул, Сэлэнгэ, Төв аймаг; • Зүүн бүсэд: Дорнод, Сүхбаатар, Хэнтий аймаг; • Говийн бүсэд:		
--	--	--	--	--	--	--	--

					Говьсүмбэр, Дорноговь, Дундговь, Өмнөговь аймаг; • Улаанбаатарын бүсэд: Улаанбаатар ба дагуул хот. Монгол Улсын бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал шинэчлэн батлагдсаны дараа үзэл баримтлалтай нийцүүлэн боловсруулалтын ажлыг эхлүүлэхээр төлөвлөн ажиллаж байна. БШУСайдын 2024 оны 04 дүгээр сарын 29-ны "Санал хүргүүлэх тухай" 1а/1707 тоот албан бичгээр ЭЗХСайдад "Монгол Улсын бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал"-д санал хүргүүлсэн байна. Хавсралт: 1 файл		
4	Салбарын барилга байгууламжийн газар хөдлөлтөд тэсвэрлэх чадвар, насжилтыг уртасгах байдалд баримтлах зарчим, зааврыг боловсруулна	Заавар	-	Судалгаа хийгдсэн байна	Судалгааны ажил хийгдэж эхэлсэн. Хугацаа болоогүй. Хавсралт: 3 файл	4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар	Өөрийн үнэлгээ: 50% Нэгжийн даргын үнэлгээ: 20% Нэгжийн даргын үнэлгээ төлөвлөсөн хугацаандаа гүйцэтгэсэн байдал: 50%

олон улсын байгууллагаас санхүүжих төсөл боловсруулах, салбар хоорондын уялдааг бодлогын удирдамжаар хангах, боловсролын чанарын үнэлгээ болон насан туршдаа суралцахуйн тогтолцоог хөгжүүлж бүх түвшний боловсролын чанар, хүртээмжийг сайжруулах бодлогын чиглэл боловсруулах

5	Ерөнхий боловсролын сургуулийн ээлжийн коэффициентийг оновчтой тооцоолох аргачлал боловсруулах	Аргачлал	-	Аргачлал	БШУЯ-ны Ерөнхий боловсролын бодлогын удирдлага, зохицуулалтын газрын ахлах шинжээч А.Цолмонгийн удирдлаган дор Ерөнхий боловсролын сургуулийн ээлжийн коэффициентийг оновчтой тооцоолох аргачлал боловсруулах судалгааны ажлыг 2023 оны 11 дүгээр сарын 28-ны өдрөөс 2024 оны 01 дүгээр сарын 30-ны өдрийн хугацаанд Нийслэлийн боловсролын газар, Дүүргүүдийн боловсролын хэлтэс, Аймгуудын Боловсрол, шинжлэх ухааны газраар дамжуулан 695 ерөнхий боловсролын сургуулиас судалгаа, мэдээллийг цуглуулж ажиллалаа. Энэхүү судалгаа, мэдээлэлд тулгуурлан Зөвлөх А.Заяадэлгэр, ЕББУЗГазрын ахлах шинжээч А.Цолмон, ахлах мэргэжилтэн Д.Соёлмаа нар "Сургуулийн ачааллыг тооцох аргачлал"-ыг Европын Холбооноос Монгол Улсын Засгийн газарт үзүүлж буй төсвийн дэмжлэгийн бүрэлдэхүүн	1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар	Өөрийн үнэлгээ: 100% Нэгжийн даргын үнэлгээ: 50% Нэгжийн даргын үнэлгээ төлөвлөсөн хугацаандаа гүйцэтгэсэн байдал: 100%
---	--	----------	---	----------	---	------------------------------------	---

					“Монгол Улсад Тогтвортой хөгжлийн зорилготой уялдсан төсвийн төлөвлөлтөөр хөдөлмөр эрхлэлтийн шинэчлэлийг дэмжих нь” техник туслалцааны төслийн хүрээнд боловсруулсан. Хавсралт: 4 файл		
6	Боловсролын сургалтын байгууллагын багш, удирдах ажилтны ёс зүйн дүрмийг боловсруулж, батлуулах	Сайдын тушаал	-	Дүрэм батлагдсан байна.	ЮНЕСКО болон Боловсролын төлөвлөлтийн олон улсын байгууллагын хамтран гаргасан "Багшийн ёс зүйн дүрмийг боловсруулж, үр дүнтэй ашиглах нь" гарын авлагад тулгуурлан Боловсролын сургалтын байгууллагын багш, удирдах ажилтны ёс зүйн дүрмийг боловсруулан ажилласан. Ёс зүйн дүрмийн төслийг яамны ажлын хэсэгт 3, 4 дүгээр сард нийт 3 удаа хэлэлцүүлж санал, шүүмж авсан бөгөөд Боловсролын судалгааны үндэсний хүрээлэнгийн эрдэмтэн нарийн бичгийн дарга С.Санжаабадам, Боловсролын хөгжлийн ирээдүй судлалын судалгааны сектор У.Туяа нараас санал, шүүмжийг давхар авсан болно. Мөн Салбарын хяналтын	1-р сар, 2-р сар, 3-р сар	Өөрийн үнэлгээ: 50% Нэгжийн даргын үнэлгээ: 50% Нэгжийн даргын үнэлгээ төлөвлөсөн хугацаандаа гүйцэтгэсэн байдал: 50%

					нэгжээс багш, удирдах ажилтны ёс зүйн зөрчилтэй холбоотой 2022, 2023 оны тойм тайлан, судалгааг авч ашигласан болно. Төслийг эцсийн хуулбарыг нэгжийн даргад танилцуулж, зөвшөөрөл авсны дагуу 2024 оны 06 дугаар сарын 03-ны өдөр яамны баримт бичгийн дотоод систем болох Эбли-ийн Олон нийтийн цэсний Хэлэлцүүлэг буланд байршуулж, яамны албан хаагчдаас саналыг авч байна. Хавсралт: 5 файл		
7	Цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн хамран сургах тойрог тогтоох аргачлалыг боловсруулахад оролцож, батлуулах	Боловсролын ерөнхий газрын даргын тушаал	-	Аргачлал батлагдсан байна.	Боловсролын ерөнхий газраас боловсруулсан "Сургуулийн өмнөх боловсролын байгууллага, ерөнхий боловсролын сургуулийн хамран сургах тойрог тогтоох аргачлал"-д саналаа тусган нэгжийн удирдлагад танилцуулж, оролцон ажилласан. Тус аргачлал Боловсролын ерөнхий газрын даргын 2024 оны 03 дугаар сарын 25-ны өдрийн А/82 дугаар тушаалаар батлагдсан. Хавсралт: 2 файл	1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар	Өөрийн үнэлгээ: 100% Нэгжийн даргын үнэлгээ: 80% Нэгжийн даргын үнэлгээ төлөвлөсөн хугацаандаа гүйцэтгэсэн байдал: 100%

№	Үүрэг даалгавар	Өгсөн субъект	Биелэлт
1	2	3	4

ХОЁР. МЭДЛЭГ ЧАДВАРАА ДЭЭШЛҮҮЛЭХ ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭНИЙ БИЕЛЭЛТ

№	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин				
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин / биелэлт	Эхэлсэн, дууссан хугаца	Биелэлтийн хувь
	1	2	3	4	5	6	7
4.1. Төрийн албаны тухай хууль, салбарын хууль, дагалдан гарсан хууль тогтоомжид заасан мэдлэг чадварыг эзэмших, тасралтгүй хөгжүүлэх							
1	Удирдлагын академийн эрхэлсэн түшмэлийн сургалтын 9 кредит цагийг бүрэн судалсан байх	Удирдлагын академийн эрхэлсэн түшмэлийн сургалтын 9 кредит цагийг бүрэн судалсан байх	7 кредит цаг	9 кредит цаг	Нийт 9 кредит цаг цуглуулж, голч оноо 3,57-оор, 2024 оны 02 дугаар сарын 23-ны өдөр амжилттай төгссөн. Хавсралт: 1 файл	1-р сар, 2-р сар	Өөрийн үнэлгээ: 100% Нэгжийн даргын үнэлгээ: 100%
2	Боловсролын асуудлаар гарч буй олон улсын судалгааны ажил, өгүүллэг уншиж мэдлэгээ дээшлүүлэх	UNESCO, OECD зэрэг олон улсын байгууллагын цахим сайтаас боловсролын хөгжлийн чиг хандлагын талаар гарч байгаа бодлогын зөвлөмж, гарын авлагыг уншиж судлах	Англи хэл дээр уншсан материалын тоо	2 ба түүнээс доошгүй	НҮБ-ын Боловсрол, шинжлэх ухаан, соёлын байгууллага болон Боловсролын төлөвлөлтийн олон улсын байгууллагын хамтран гаргасан "Багшийн ёс зүйн дүрмийг боловсруулж, үр дүнтэй ашиглах нь" гарын авлагыг англи хэлнээс орчуулан судалж, ажлын хэрэгцээндээ хэрэглэн ашиглалаа. Хавсралт: 2 файл	1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар	Өөрийн үнэлгээ: 100% Нэгжийн даргын үнэлгээ: 100%
3	Шинээр батлагдсан хууль	Шинээр батлагдсан хууль тогтоомж	5 хууль, тогтоомж	10	2024 оны эхний хагас жилийн байдлаарх дараах хууль,	1-р сар, 2-р сар, 3-р сар,	Өөрийн

	тогтоомж, тогтоол шийдвэрийг судлах	тогтоол судлах	шийдвэрийг		тогтоомжийг уншин судалж, ажлын чиг үүрэгтээ хэрэгжүүлэн ажиллаж байна. Үүнд: - Боловсролын ерөнхий хууль - Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын хууль - Мэргэжлийн болон техникийн боловсрол, сургалтын тухай хууль - Дээд боловсролын тухай хууль - Шинжлэх ухаан, технологийн тухай хууль - Барилгын тухай хууль - Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль - Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хууль - Засгийн газрын 2024 оны 39, 102, 103, 104 дүгээр тогтоол гэх мэт	4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар	үнэлгээ: 100% Нэгжийн даргын үнэлгээ: 100%
--	---	-------------------	------------	--	--	---	---

ТАЙЛАН ГАРГАСАН:

Газар зүйн мэдээллийн системд суурилсан төлөвлөлт, хөгжүүлэлт, зохицуулалт хариуцсан шинжээч, Төмөрбаатар Амартүвшин
/...../ Огноо: